



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны ээлжит 04 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 04 дүгээр хуралдааныг 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар /2026-03-12/ Радио, телевизийн хөтөлбөрт хийсэн мониторингийн 2025 оны жилийн эцсийн тайлан; Гадаад орнуудын зохицуулах байгууллагууд радио, телевизийн хөтөлбөрт агуулгын хүрээнд хяналт, мониторинг хийдэг эсэх талаар танилцуулга (Хорооны 2026 оны ээлжит 03 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх); Мобиком корпораци ХХК-ийн ирүүлсэн гомдлын асуудлаар хийсэн санал, дүгнэлтийг танилцуулах (Хорооны 2026 оны ээлжит 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл сэргээх тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай дүгнэлт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны нийт 10 (Тогтоол №31-40, 2026-03-12) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Энэхүү хуралдаанаар Радио, телевизийн хөтөлбөрт 2025 онд хийсэн мониторингийн нэгдсэн дүн, хэрэгжилтийн тайлан болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга; Хорооны 2026 оны ээлжит 03 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд Гадаад орнуудын зохицуулах байгууллагууд радио, телевизийн хөтөлбөрт агуулгын хүрээнд хяналт, мониторинг хийдэг эсэх талаар танилцуулгыг тус тус сонсов. Радио, телевизийн хөтөлбөрт 2025 онд хийсэн мониторингийн нэгдсэн дүн, хэрэгжилтийн тайлан болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулгыг хэлэлцээд, холбогдох бүтцийн нэгж (ӨНЗГ)-д мониторингийн үр дүнгээр дүн шинжилгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, хариуцлага тооцох талаар хугацаатай үүрэг чиглэл өгөхөөр тогтов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 23 дугаар хуралдаанаар Мобиком корпораци ХХК-иас ирүүлсэн 2 хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзаж Хорооны даргын 2025 оны 01/2354, 01/2354 тоот албан бичгээр мэдэгдэл хариуг хүргүүлсэн болно. Гэвч дээрх татгалзсан үндэслэлийг үл зөвшөөрөн Мобиком корпораци ХХК-иас 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Гомдол уламжлах тухай” 1/4651 тоот болон 1/4652 тоот албан бичгээр Хорооны дарга, гишүүдийн нэр дээр ирүүлсэн бөгөөд ХХЗХ-ны 2026 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар бусад асуудлын хүрээнд ирүүлсэн гомдлыг хуулийн хүрээнд судлан үзээд санал, дүгнэлтээ 30 хоногийн дотор Хорооны хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Ажлын албанд үүрэг болгосон. Энэхүү удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Хорооны 2026 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар Мобиком корпораци ХХК-ийн ирүүлсэн гомдлын асуудлаар ажлын албаны болон хууль эрхзүйн дүгнэлтийн тухай албан мэдэгдлийн төслийг тус тус

танилцуулав. Энэхүү асуудлаар Ажлын албаны дүгнэлтийг дэмжиж, албан мэдэгдлийг Хорооны даргын гарын үсэгтэй албажуулан хүргүүлэхээр тогтов.

Тус хорооны 2026 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл сэргээх тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай дүгнэлт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох ажлын хэсэг, бүтцийн газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 10 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 10 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 31 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 7 хуулийн этгээдэд 7 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.13 дахь хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 32 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Аз монобе жи пи эм ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200220 тусгай зөвшөөрлийг) сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.13 дахь хэсгийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 33 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 6 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг) сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 34 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Эргэлдэй ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200197 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 35 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Ёл цуурай ХХК: Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” 13000035 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 36 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар нэр бүхий 9 хуулийн этгээдийн 9 тусгай зөвшөөрлийг (“Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх”-1, “Харилцаа холбооны

сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг-8) хүчингүй болгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Төв ньус ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 37 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Төв ньус ХХК: Төв аймгийн нутаг дэвсгэрт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх” 13000141 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Номгон лхахүү хүслэн заяа ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 38 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Номгон лхахүү хүслэн заяа ХХК: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43400074 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Топологи ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 39 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Топологи ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100516 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 40 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдэд олгосон 7 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгаж тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2026-03-20